



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймгаг, Хэртэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

᠐3.᠒3 № 314


танай _____ -Ы № _____ -Т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Т.БАЯРЖАРГАЛ ТАНАА

Танай байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг акт, албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитаар өгсөн акт, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 5-р сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү

Хавсралт..... хуудас



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Ch. Erdenebaatar* Ч.ЭРДЭНЭБААТАР

02357

ХЭНТИЙ АЙМГА ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/01/НА-СТА- ТБОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112 Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Аудитор: Х.Еркегүл Утас: 99040705
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлого үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
3.2.5	9
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
Байгууллагын үйл ажиллагаа	11
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	14
4.2.1 Залруулсан алдаа	14
4.2.2 Төлбөрийн акт	14
4.2.3 Албан шаардлага	14
4.2.4 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15
6. Төлбөрийн акт, албан шаардлага	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.23 № 313

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Олон жилийн өмнө үүссэн халаалтын төлбөрийн өглөгийг тухайн өр үүссэн тайлант хугацаанд санхүүгийн тайландаа тусгаж өглөгөөр бүртгээгүй, төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогыг тайлант хугацаанд төвлөрүүлээгүй зэрэг зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно" гэсэн заалтад нийцээгүй, тасалбар болголт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Хэнтий аймгийн
Нийтлэг үйлчилгээ
ОНӨААТҮГ-ын
2021 оны санхүүгийн
тайланд

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,927,393.27	5,340,018.28
1.1.2	Дансны авлага	2,355,864.90	2,472,610.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	36,445.22	-
1.1.4	Бусад авлага	369,760.00	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	64,801,332.21	65,270,423.20
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10	Системийн авлага	-	-
	Эргэлтийн хөрөнгийн дүн	70,490,795.60	73,083,051.48
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	316,212,142.48	308,149,796.12
1.2.2	Биет бус хөрөнгө	79,345,000.00	79,345,000.00
1.2.3	Дуусаагүй барилга	-	-
1.2.4	Биологийн хөрөнгө	-	-
1.2.5	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.6	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.8	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.2.10	Хуримтлагдсан элэгдэл	-	-
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	395,557,142.48	387,494,796.12
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	466,047,938.08	460,577,847.60
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	-	-
2	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
			4,323,620.80
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	-	205,000.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-

Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ		ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12	Системийн өглөг		
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0.00	4,528,620.80
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Урьдчилж орсон орлого - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	-	-
2.1.2.5	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	0.00	4,528,620.80
2.3	Эздийн өмч	119,029,501.00	119,029,501.00
2.3.1	Өмч: - төрийн	119,029,501.00	119,029,501.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	250,428,134.82	250,428,134.82
2.3.7	Эздийн өмчийн бусад хэсэг	20,000,000.00	20,000,000.00
2.3.8	Хойшлогдсон орлого	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	76,590,302.26	66,591,590.98
	Эздийн өмчийн дүн	466,047,938.08	456,049,226.80
	Өр төлбөр ба Эздийн өмчийн дүн	466,047,938.08	460,577,847.60

2.2 Аудит хийсэн орлого үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	395,029,667.00	355,936,297.00
2	Борлуулалтын өртөг		2317144297
3	Нийт ашиг (алдагдал)	395,029,667.00	355,936,297.00
4	Түрээсийн орлого	16,709,294.00	11,450,382.00
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого		
9	Борлуулалт маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	443,391,759.43	377,288,890.28
11	Санхүүгийн зардал	109,400.00	96,500.00
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(31,762,198.43)	(9,998,711.28)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(31,762,198.43)	(9,998,711.28)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(31,762,198.43)	(9,998,711.28)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
26	Бусад олз гарз	-	-
27	Орлогын нийт дүн	-	-
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	(31,762,198.43)	(9,998,711.28)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгд сөн капита л	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагд сан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	119,029,501.00	-	250,428,134.82	20,000,000.00	108,352,500.69	497,810,136.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(31,762,198.43)	(31,762,198.43)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
2020 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	119,029,501.00	-	250,428,134.82	20,000,000.00	76,590,302.26	466,047,938.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(9,998,711.28)	(9,998,711.28)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-	-
2021 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	119,029,501.00	-	250,428,134.82	20,000,000.00	66,591,590.98	456,049,226.80

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	2317144237
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	381,210,646.00	332,749,361.90
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	554,000.00-	900,000.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	324,525,504.00	295,112,345.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого		
1.1.6.1	Банк хоорондын гүйлгээ	56,145,142.00	36,737,016.90
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	378,888,971.70	330,336,736.89
1.2.1	Ажиллагчдад төлсөн	233,047,380.00	163,696,051.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	61,990,395.07	50,452,046.75
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,191,098.00	11,946,466.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	13,603,964.63	16,557,505.34
1.2.5	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,792,000.00	7,500,000.00
1.2.9.1	Татварын байгууллагад төлсөн	19,724,316.00	13,216,216.00
1.2.9.1	Даатгалын төлбөрт төлсөн	115,830.00	-
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	33,423,988.00	66,968,451.80
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,321,674.30	2,412,625.01
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.1.1	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.1.1	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.2	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.4	Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	ХО бусад мөнгөн орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,900,000.00-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,900,000.00-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-

Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.2.4				
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		-	-
2.2.6	ХО бусад мөнгөн зарлага		-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,900,000.00)	2317144297 СНӨА0046 0074082	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-	-
	Мөнгөн орлогын дүн (+)		-	-
3.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-	-
3.1.1	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан			
3.1.2			-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив		-	-
3.1.4	СҮА-ны бусад мөнгөн орлого		-	-
	Мөнгөн зарлагын дүн (-)		-	-
3.2	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-	-
3.2.1	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		-	-
3.2.2	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн			
3.2.3			-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг		-	-
3.2.5	СҮА-ны бусад мөнгөн зарлага		-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0.00		0.00
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	331,674.30		2,412,625.01
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,595,718.97		2,927,393.27
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,927,393.27		5,240,018.28

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл нь АЗДТГ-ын байранд байрлаж байгаа төрийн захиргааны байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, төсөвт зардал болон нийтлэг үйлчилгээг хариуцан ажиллах үндсэн үүрэг бүхий орон нутгийн өмчит үйлдвэрийн газар юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 443.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзэхэд нийт зардал буурсан тул дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын зорилго нь аймгийн ЗДТГ-ын байранд байрлаж байгаа төрийн захиргааны байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, төсөвт зардал болон нийтлэг үйлчилгээг хариуцан ажиллахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг

1. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид, Засаг дарга түүний тамгын газрын шаардлагад нийцсэн нийтлэг үйлчилгээг явуулж, тэдгээрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах санхүү, аж ахуй, хангалтыг хариуцах
2. Аймгийн ЗДТГ-ын гадна болон дотор талын цэвэрлэгээ, үйлчилгээ, өрөө тасалгааны тохижилт, цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, барилгын ба сантехникийн урсгал засвар, харуул хамгаалалтын үйлчилгээг хариуцах, нийтийн хоол цайгаар үйлчилж түүнийхээ үр дүнгээр үйлчлэгчээс хөлс авах
3. Аймгийн ЗДТГ-ын барилгын гадна болон дотор талын засвар үйлчилгээтэй холбоотой асуудлаар үйлчлэгч байгууллагатай хамтран тохиролцож жил жилийн төсвийн төсөлд тодорхой асуудлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байх
4. Өмч, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хууль тогтоомжийн дагуу хяналт тавих.
5. Үйл ажиллагааны баталгаа нь гэрээ байх бөгөөд эрхэлж байгаа үйлчилгээ, нийлүүлсэн бүтээгдэхүүн нь улсын чанар, стандартын шаардлага хангасан байна
6. Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны шугамаар ирсэн зочин төлөөлөгчдийн ажиллах нөхцөл, байр хоол зэрэг үйлчилгээг хариуцаж зохион байгуулах
7. Аймгийн удирдлагуудын гадаад, дотоод арга хэмжээнүүд болон баяр, ёслолын арга хэмжээний үйлчилгээг зохион байгуулж, бэлэг дурсгалын зүйлийн санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж байх
8. Эрхэлж буй ажлын хүрээнд зайлшгүй шаардлагатай асуудлаар ИТХ, Засаг даргад асуудал боловсруулан шийдвэрлүүлэх
9. Зорилгодоо нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа явуулна
10. Ашгийн төлөө байгууллага байна гэж тодорхойлсон байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь аймгийн Засаг даргын 2007 оны 01 дүгээр захирамжийг үндэслэн байгуулсан байна. Компанийн ТУЗ томилогдоогүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,927.4	5,340.0	2,412.6
БХХО			
Авлага	2,762.1	2,472.6	-289.5
Урьдчилгаа			
Бараа материал	64,801.3	65,270.4	469.1
Үндсэн хөрөнгө	316,212.1	308,149.8	-8,062.3
Биет бус хөрөнгө	79,345.0	79,345.0	0
Нийт хөрөнгийн дүн	466,047.9	460,577.8	-5,470.1
Өр төлбөрийн дүн	0		
Богино хугацаат өглөг	0	4,528.6	4,528.6
Урт хугацаат өглөг	0	0	0
Эздийн өмч	119,029.5	119,029.5	0
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	466,047.9	456,049.2	-9,998.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	466,047.9	460,577.8	-5,470.1

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд 5.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдэлд 2.4 сая төгрөгийн түрээсийн авлага бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 65.0 сая төгрөг ба өмнөх оноос материаллаг өөрчлөлт ороогүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8.1 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэлтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 4.5 сая төгрөг болж өссөн нь тайлант хугацаанд төсөвт төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлснийг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж залруулсантай холбоотой.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж зохих байгууллагаар батлуулаагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

"Баян эрдэс" ХХК-тай олон жилийн өмнө үүссэн 6.4 сая төгрөгийн халаалтын өртэй гэх боловч санхүүгийн тайландаа тусгаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Түрээсийн орлогын 40 хувь буюу 5.2 сая төгрөгийг тайлант хугацаанд төвлөрүүлээгүй ба аудит хийх хугацаанд 4.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн тул үлдэгдэл 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 17.6 сая төгрөгийн 2 мөнгөн гүйлгээ, зарлагын 57.8 сая төгрөгийн 5 мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг мэдээллийг мэдээлээгүй, 46.0 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээ болон хагас жилийн санхүүгийн тайланг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

ЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад бэлэг дурсгалын зардалд 1.4 сая төгрөгийг бэлэг дурсгал, шагнал урамшуулалд зарцуулсан нь тус тогтоолын 1.3 дахь заалтад нийцээгүй байна гэж үзлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 50 хувьтай байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил давтагдаж зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 263.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 133.3 сая төгрөгийн алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 129.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

- Аймгийн ЗДТГ-т бүртгэхээр шийдвэр гарсан 120.1 сая төгрөгийн 1 байшин, 2 машиныг үндэслэлгүй үндсэн хөрөнгийн дансанд орлогоор бүртгэсэн.
- Худалдаж авсан 0.2 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн.
- Программ хангамж худалдан авсан гэж 1.2 сая төгрөгийн биет бус хөрөнгийг орлогоор бүртгэсэн боловч анхан шатны баримт байхгүй, худалдан авах гэрээ байгуулаагүй, тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн стандарт шаардлагыг хангахгүй тул ашиглаагүй.
- Төсөвт төвлөрүүлэх орлогын үлдэгдэл 4.3 сая төгрөгийг санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд төвлөрүүлснийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж залруулав.
- Үндсэн хөрөнгийн тайлан дэлгэрэнгүй журналаас 8.9 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн зэрэг алдаануудыг санхүүгийн тайланд залруулга хийв.

4.2.2 Төлбөрийн акт

Төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогыг 0.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

4.2.3 Албан шаардлага

- Олон жилийн өмнө үүссэн 6.3 сая төгрөгийн халаалтын өрийг санхүүгийн тайландаа тусгаагүй
- Бэлэг дурсгалын зардалд 0.5 сая төгрөг, шагнал урамшуулалд 0.9 сая төгрөг, нийт 1.4 сая төгрөг зарцуулж, эрх бүхий байгууллагаас гарсан тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 17.6 сая төгрөгийн 2 мөнгөн гүйлгээ, зарлагын 57.8 сая төгрөгийн 5 мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг мэдээллийг мэдээлээгүй, 46.0 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээ болон хагас жилийн санхүүгийн тайланг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрч өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн боловч зөрчил дахин давтагдсан.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

- 1 Байгууллагын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.3 дахь заалтыг үндэслэн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ	6	140.6	3	133.3	1	0.9	1	6.4	1	0
Дүн		6	140.6	3	133.3	1	0.9	1	6.4	1	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ	2	122.9					2	122.9		
Дүн		2	122.9					2	122.9		
Нийт дүн		8	263.5	3	133.3	1	0.9	3	129.3	1	0



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 22 /А2370449
ХЭА - 2022/01/НА ЕТА-ТШ/З Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд::

Төрийн өмчийн байр түрээслүүлсний орлогын 891.7 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-д “Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 хувиар тогтоосугай” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.2 -д “төрийн болон орон нутгийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсөвт дутуу төвлөрүүлсэн 891.7 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын захирал Т.Баяржаргал, нягтлан бодогч О.Арсланбаатар нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЕРКЕГҮЛ

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 194/А2370449
ХЭА - 2022/01/НА-СТА ТУЛЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 17.6 сая төгрөгийн 2 мөнгөн гүйлгээ, зарлагын 57.8 сая төгрөгийн 5 мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг мэдээллийг мэдээлээгүй, 46.0 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээ болон хагас жилийн санхүүгийн тайланг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг нийт 121.5 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг," 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, бүрэн мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймаг Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын захирал Т.Баяржаргал, нягтлан бодогч О.Арсланбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Х.ЕРКЕГҮЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 195/АДЗ70449
ХТН-2022/01/НА ЕТН-ТЧЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Баян эрдэс" ХХК-тай олон жилийн өмнө үүссэн 6,371.6 мянган төгрөгийн халаалтын өрийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, санхүүгийн тайландаа тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 -д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагад төлөх өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын захирал Т.Баяржаргал, нягтлан бодогч О.Арсланбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЕРКЕГҮЛ

Д.ОЮУНТУЯА

2317144237
СНӨА0046 9074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 193/А2370 449
ХЭА-2022/01/НА - СА - ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бэлэг дурсгалын зардалд 450.0 мянган төгрөг, шагнал урамшуулалд 950.0 мянган төгрөг зарцуулж, эрх бүхий байгууллагаас гарсан тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дугаар 1.3-д "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын захирал Т.Баяржаргал, нягтлан бодогч О.Арсланбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЕРКЕГҮЛ

Д.ОЮУНТУЯА

